

2 - 75371



\* 0 2 0 7 5 3 7 1 \*

26.89/5Мон/Н.357

даны мэндэлсний 840  
л Улс байгуулагдсаны  
0 жилийн ойд

Сайн эрс Д.Наянтай  
Шарайд Г.Батжаргал

# БӨРТЭ ХАТНЫ УУГУУЛ НУТГААР



Дархан 2001, 2006 он



Сайн эрс Д.Наянтай  
Шарайд Г.Батжаргал



## БӨРТЭ ХАТНЫ УУГУУЛ НУТГААР

/Тойрон аялагчдад зориулсан  
"Чингис хааны төрсөн нутгаар".  
2001 оны номын, нэмж засварласан хоёрдох хэвлэл/

Дархан-Уул аймгийн Засаг даргын тамгын газар  
Ахмадын хороо  
Эмэгтэйчүүдийн холбоо  
"Их Засаг" Их сургууль

Хянан тохиолдуулсан: Ч.Оюунцэцэг  
Д.Тогтуур

Дархан  
2001, 2006 он



**Номыг хэвлэхэд ивээн тэтгэсэн:**

*Дархан-уул аймгийн засаг даргын тамгын газар, дарга  
С.Хаянхярваа*

*Чингис хааны нэрэмжит Их засаг Их сургууль, Захирал  
Монгол Улсын гавъяат багш доктор профессор Н.Ням-  
Осор нарт гүн талархал илэрхийлье.*

Зохиогчийн эрх@, зохиогчийн гэрчилгээ 1539/02

Эхийг компьютерт бэлтгэсэн Д.Энхтайван, Ч.Оюунцэцэг

Гэрэл зургийг авч хэвлэлд бэлтгэсэн Д.Наянтай

Хавтас, зураг дизайныг Ж.Байгаль

Дархан. Бурхантын хөндий

## ӨМНӨХ ҮГ

Би энэхүү замын тэмдэглэлээ бичихийн өмнө бяцхан оршил тайлбар хэлмээр санагдлаа. Учир нь: Чингис хааны түүхт дурсгалт газраар аялах санаачлага анх гаргасан номыг хамтран зохиогч агсан Г.Батжаргал бид 2 залуу насандаа Дорнод айтгийн Халх гол суманд цуг ажиллаж танилцсан юм. Хэдэн жилийн өмнө ийм аялал зохиож хамтарч гэрэл зурагтай ном бичих баримтат кино хийхийг санал болгосон билээ.

Би зөвшөөрч хамтарч төлөвлөгөө хийж бэлтгэсэн боловч Г.Батжаргал гараа гэмтээснээс анхны аялалд оролцож чадаагүй тул түүний төрсөн нутаг Дорнод аймгад явахад хойшлуулж аяллынхаа тухай "Чингис хааны төрсөн нутгаар" номоо 2001 онд хэвлүүлсэн. Одоо миний бичсэн видео бичлэг хадгалагдаж байна. 2002 онд "Хатаад -Этэгтэйчүүд аяллыг үргэлжлүүлэн зохион байгуулж атжилттай болсон боловч энэхүү номыг эхлээд бичиж байсан аймгийн Ахмадын хороон дарга Г.Батжаргал маань үл бүтэх хүний гарт хорлогдож бидэнд эмгэнэлт явдал тохиолдов. Миний бие Солонгос улсад ажиллаж байсан хүүхдийн бие муудаж гэнэт дуудлага ирсэн тул жил гаруй хугацаанд явж ирээд цаг хугацаа хойшилсон ч журмын нөхрийн санаачилсан ажлын үр дүнг уншигч олондоо хургэх түүний гэгээн дурсгалыг хүндэтгэх чин зоригийг барин энэхүү номыг бичлээ. Дээдсийн их түүхийг оюундаа шингээсэн хуудас нь үл тоологдох их номын ухаан эдүгээ бидний дунд үгүйд харамсавч үл барагдана. Гэвч хүслийг нь гүйцээх их хувь оноогдсонд бэлэгшнээм.

Энэ аяллын зарим замын тэмдэглэл эх материал үүрэгдсэн тул бэрхиээлтэй байснаас цаг хугацаа нэлээд хойшилсонд хүлцэл өчье.

Энэ аяллыг Дархан-Уул аймгийн Засаг даргын тамгын газар, Ахмадын хороо Монголын болон аймгийн Эмэгтэйчүүдийн холбоо Чингис хааны нэрэтжит Их засаг Их сургуулиас хамтран зохион байгуулсан бөгөөд зөвхөн нэг үр дүн нь манай аялагчид Монголын Эмэгтэйчүүдийн холбоо Дорнод аймгийн удирдлагатай хамтран 2002 онд тус аймгийн төвд Бөртэ хатны хөшөөний суурь тавих ёслолыг санаачлан хийж байсан бол 2004 онд хөшөөний загвар шалгарч Улаанбаатар, Чойбалсан хотод Төрийн их Бөртэ хатны хөшөө баригдах болсонд баяртай байна.

Бид олон янз бичигдсэн хэвлэлээс ишлэл авахыг хүссэнгүй гагцхүү "Монголын нууц товчоо" номыг голлон гарын авлага болгон түүнчлэн ном бичигдсэн загвараар аяллын гишүүн Ч.Оюунцэцэгийн замд бичсэн шүлгээс оруулж бичлээ. "Монголын нууц товчоо" хэмээх агуу бүтээл нь тухайн үеийн манай улсын эгэл түүх өдгөөгийн их түүх бөлгөө.

Ингээд "Бөртэ хатны уугуул нутгаар" хамт аялахыг ухаант уншигч танаас учирлан хүсье.

Их түүх гэдэг санах дээдлэхийн ухаан

Их хүлмүүн гэдэг бишрэл хүндлэлийн тэнгэр авай.

/Ч.О/

Ц.Наянтай

Нэг. Аялалын эхэн буюу Хан Хэнтийн нутгаар:

Манай энэ удаагийн Хатад эмэгтэйчүүд аялал нь өнгөрсөн онд Чингис хааны төрсөн нутгаар хийгдсэн аялалын үргэлжлэл юм.

Усан морин жилийн зуны дунд улаан морин сарын шинийн арван нэгний Цагаан бич өдөр буюу 2002 оны 6-р сарын 21-ний өглөөний морин цагт Дархан-Уул аймгийн сүлд болсон Хаан бугуйвч бүхий өндөрлөгөөс уламжлал ёсоор гараагаа эхэллээ.

Энэ өдрийн өмнөх шөнө бороо орж өглөө нь тунгалаг нар гийсэн маш сайхан өдөр байсан нь биднийг аяллын замдаа сайн явахыг Бурхантын бууралхан хөндий, буянт дээдэс минь ивээх мэт санагдаж байлаа.

Аялалыг аймгийн засаг даргын тамгын газрын дарга.Эмэгтэйчүүдийн холбооны тэргүүн 3 Цэнгэлсайхан алд цэнхэр хадаг аяга дүүрэн сүү барьж аяллын замдаа сайн явж ,зорьсон хэргээ амжилттай бүтээж ирэхийг хүсэн ерөөв.

“...Цэгц хатдын нутгаар нь аялж яваад ирье  
Цэн хун шувуу шиг ганганаж яваад ирье  
Захиж хэлсэн үгийг тань санаж яваад ирье  
Заяа буян тэгш алдраа өргөөд ирье.” гэж Хатад тойрон аяллын хамт олны төлөөлөгч Манай аяллын зохион байгуулагчдын нэг, аймгийн Эмэгтэйчүүдийн ордны сургалтын төслийн менежер Ч.Оюунцэцэг хариу үгийг шүлэглэн халуун сэтгэлээ өргөлөө

Тус аялалд:

Дархан-Уул аймгийн Ахмадын хорооны дарга агсан

Г.Батжаргал

Эмэгтэйчүүдийн Холбооны ажилтан О.Болормaa,

Ч.Оюунцэцэг

УГТСЭШХ-ийн ажилтан зураглаач Д.Наянтай

Монголын Тогооч нарын Холбооны Дархан-Уул аймаг дахь салбарын тэргүүн, төр захиргааны ахмад ажилтан Д.Тогтуур

Эрүүл мэндийн газрын их эмч Д.Оюунгэрэл

“Монгол алт” ХХК-ний ажилтан Д.Цэрэнхан

Хонгор сумын Эмэгтэйчүүдийн зөвлөлийн дарга

Д.Цэрэнмягмар

УБ хотын ИЗИС-ийн нийгмийн ухааны багш Ю.Эрдэнэчимэг

Мөн сургуулийн түүх нийгмийн ухааны багш Ц.Чулуунцэцэг

ДА 45-41 дугаартай фургон машины жолооч

Б.Самбалхүндэв нарын бүрэлдэхүүнтэй аяллын баг явсан билээ.

Аялагчдыг аймгийн ахмадын хороо Эмэгтэйчүүдийн Холбооны удирдах хүмүүс тэдний ар гэрийнхэн Дархан-Уул аймгийн хүндэтгэлийн хаалга найрамдлын 6 баганат өндөрлөг хүртэл үдэж гаргав.Энэхүү өндөрлөгийн дэргэд идээ будааныхаа дээжийг суугуул нутгийнхаа уул, овоо ус гол мөнх хөх тэнгэртээ цацал болгон өргөж их эзэн богд Чингэс хааны төрсөн Хан Хэнтий уулын өвөр Онон Хурхын үзэсгэлэнт сайхан нутгаар аялж Монголын алдарт их тал дундуур дорно зүг дөлгөөхөн урсах Хэрлэн голын дэнж дээр өнө эртнээс эдүгээ хүртэл суурьшсан Сэцэнхан аймгийн Санбээсийн өргөө, одоогийн Дорнод аймгийн төв Хэрлэн сум /Чойбалсан хот/-ыг зорин 2000 км аялах аяллын гараагаа эхэллээ.

Дархан Сэлэнгийн нутгийн заагХустайн давааны оройд түр саатан өвөг дээдсээс уламжлан ирсэн зан заншлаар овоонд чулуу нэмээд цааш хөдөллөө.

Энэ өдрийнхөө үдийн үед нийслэл хотдоо хүрч Чингис хааны нэрэмжит Их Засаг Их Сургуульд очив. Тус сургуулийн ректор, түүхийн шинжлэх ухааны доктор, профессор Н.Ням- Осор биднийг элэгсэг дотно хүлээн авч сургуулийнхаа хичээлийн анги танхим, багш оюутны эрдэм шинжилгээний бүтээлүүдээс үзүүлж, бидний аялалын бүрэлдхүүнд орж явах энэ сургуулийн түүх, нийгмийн ухааны багш, магистр Эрдэнэчимэг, Чулуунцэцэг нарыг танилцуулснаар аялалын баг бүрдэл болов.

Манай аяллынхныг үдэж гаргахаар Бөртэ хатны уугуул нутаг Дорнод аймгийн халх гол сумын харьяат одоо ШУА-ийн химийн хүрээлэнд ажиллаж байгаа Алтансүвд хүрэлцэн ирсэн байв.Б.Алтансүвд: "Миний төрж өссөн унаган нутаг бол Халхын- гол, Хамар-даваа, Буйр нуурын араар байдаг юм. Энд их хатан

*Бөртэ хатны уугуул нутгаар*

---

Бөртэ үжин төрсөн гэж түүхэнд тэмдэглэгдсэн байдаг. Энэ нутгаар аялаж, уугуул нутагт нь босгох хөшөөний шав тавих, хүндтэй сайхан аялал зохион байгуулан явж байгаа Дархан-Уул аймгийн эмэгтэйчүүд та бүхэнд баярлалаа. Манай нутгаар сайхан аялаад ирээрэй гээд шар торгон хадаг, халуун савтай цай, То вангийн холбогдолтой ном барив.

Чингис хааны нэрэмжит Их  
засаг их сургууль Чин зоригт  
залуусын Эрдэмд шамдсан өргөөнд  
Доктор проффесор Ням-Осор  
Дотно сайхан сэтгэлээр угтаж  
Оюуны суу бүтээлээ дурсгаж Одох  
замын ерөөл өргөв.../Ч.О/

Бид эндээс хөдлөж Богд хан уулын араар урсах хатан тунгалаг Туул голын гүүрээр гарч авто техникийн шалган бүртгэх товчоонд очиж дүрэм журмын дагуу унаа машиныхаа техникийн бүрэн бүтэн байдлыг шалгуулав. Энд Монголын Эмэгтэйчүүдийн Холбооны Ерөнхийлөгч Эрдэнэчимэг, Гүйцэтгэх захирал Билэгдэмбэрэл нар "Хатад-Эмэгтэйчүүд"-ийн аялалынханыг үдэж гаргахаар очсон байв.

Монголын Эмэгтэйчүүдийн Холбооны Ерөнхийлөгч Эрдэнэчимэг аялагч "Хатад"-д хандаж хэлэхдээ Их эзэн Чингис хааны мэндэлсний 840, Монгол тулгар төр байгуулагдсаны 800 жилийн ой угтаж Дархан-Уул аймгийн засаг даргын тамгын газар, Ахмадын болон Эмэгтэйчүүдийн байгууллагууд хамтран эмэгтэйчүүд бие дааж алс холын анхны томоохон аялал зохион байгуулж байгаад бид маш их баяртай байна. Энэ аялалд Чингис хааны нэрэмжит Их Засаг Их Сургууль түүхийн мэргэжлийн багш нараа оролцуулж байгаа нь энэ аялалын түүхэн ач холбогдлыг өндөрт өргөж байна. Манай эмэгтэйчүүд энэхүү 2000 гаруй км замыг цөөн хоногт туулж Монгол түмний түүхэнд алтан үсгээр бичигдсэн Хан-Хэнтий нурууны өвөр, Ононы Дэлүүн болдог, төрийн их хатан Бөртэ Үжиний төрж өссөн уугуул нутгаар аялан хөшөөнийх нь шав тавих хүндтэй бөгөөд хариуцлагатай үүргийг хүлээж яваад сэтгэл нэн өндөр байна" гэдгээ илэрхийлж алд цэнхэр хадгаан

өргөн барьж, монгол ёсоор аяны замд сүү өргөн мялаав. Бидний аялал цааш үргэлжлэн түүх домогт Баяндавааны оройд гарлаа. Энэ давааны талаар Чингис хааны нэртэй холбоотой домог яриа, түүхэн баримтуудыг өнгөрсөн онд хийсэн авто тойрон аялалын замын тэмдэглэлээр бичсэн “Чингис хааны төрсөн нутгаар” номондоо өгүүлсэн учир энд дахин бичээгүй болно.

Дархан-Уул аймгийн Хаан бугуйвч бүхий Баганат өндөрлөгөөс Баян давааны оройг хүртэл 292 км байна. Энэ зам нь 22-ын Шалган Бүртгэх Товчооноос их тойргоор явж ИЗИС- ийн 1-р байраар ороод Туул голын Баянзүрхийн гүүрээр гарсан зам болно. Баяндаваа нь Богдхан уулын зүүн үзүүрийн төгсгөл юм. Давааны ар хормойгоор тунгалаг устай хатан Туул гол Баруун зүг урсаж голын хоёр эргээр битүү бургасан шугуй ногоорно. Түүнээс цааш горхи Тэрэлжийн эгц хадан байц цохио бүхий элгэн улаан уул хад чулуу нэн сүртэй харагдана. Зүүн хойд зүгт хөх тэнгэрийн хаяатай нийлсэн хан Хэнтий нурууны мөнх цаст ноён оргил Асралт хайрханы салбар уулс нүдний үзүүрт униартана. Эндээс зүүн тийш явах тусам өндөр уул даваа ой мод үгүй болж хээрийн бүсийн жижиг толгод үргэлжилнэ. 1990-ээд оны дундуур Налайхаас Төв аймгийн Эрдэнэ сумын төв хүртэл хатуу хучилттай засмал зам тавихад Япон улсын тусламжаар Зуун модны элсний хөтлөөс Баян давааны өвөр хүртэл зам тавьсан юм байна. Давааны орчимд тавьсан энэ замд хийц загвар сайтай усны үерийн шуудуу хамгаалалт нь чанартай хийгдсэн гүүр байлаа. Давааны орой дээр олон зууны турш босгосон чулуун овоо хадаг яндар нь салхинд намиран сүртэй харагдана.

Аяллаа үргэлжлүүлэн Төв аймгийн Эрдэнэ сумын төвөөр дамжин Мянганы замаар Дөтлүүрийн даваа давж Баян дэлгэр сумын нутгаар дайран Багануурын уурхай хүрлээ. Хэрэв Дөтлүүрийн давааны өврөөр тойрч Багануур хүрэх бол их зохиолч Д.Нацагдоржийн төрсөн газар Гүн Галуутайгаар орж болно.

Энэ нь төв замаас 20 орчим км тойрно. Бага-нуурын уурхайн төвөөс зүүн урагшаа 8 км яваад Хэрлэн голын гүүр хүрнэ. Дарханаас энэ гүүр хүртэл 373 км, 22-ын товчооноос 163 км байна. Энэ гүүрийн зүүн талд "Хэрлэнгийн хөдөө арал"-аад салах замын тэмдэг тавьжээ.

*Бөртэ хатны уугуул нутгаар \_\_\_\_\_*

Бид буцаж ирэхдээ хөдөө аралд Дэлгэрхаан сумын нутагт байгуулсан Чингисийн онгоныг үзэх тул нар зөв тойрч Чингисийн төрсөн нутаг Дэлүүн болдог Биндэрийн овооны чулуун дээр сийлсэн 400 гаруй тамга, дээдсийг оршоосон "Ихсийн газар" -ыг үзэхээр аяллаа үргэлжлүүлээ.

Бидний явж чадаагүй зам: Хэрлэн голын гүүрээс зүүн хойшоо гарч Бүргэ-Эрэг, Хар зүрхний Хөх нуурт босгосон дурсгалын баганыг үзэж болно.Энд /МНТ-122/...Тэмүүжин нар тэндээс нүүж Хүрэлх доторх Сэнгүр /Цэнхэрийн гол/ горхины Хар зүрхний Хөх нуурт очиж буув./МНТ-123/Алтан Хучар, Сачи, Бэхи бүгдээрээ зөвлөлдөж Тэмүүжинд өгүүлрүүн "Чамайг хаан болгоё.Тэмүүжин чамайг хаан болгож бид:

Олон дайнд оройлон явж  
Онц гуа охидыг олзолж  
Ордон сайхан гэрийг авч  
Олны хаан Тэмүүжинд өргөө.

...Эзэн Тэмүүжин чиний  
Эе зарлигийг  
Эс дагах бол  
Эзэлсэн ардыг авч  
Эмс хөвгүүдийг булааж  
Энэ биеийг минь  
Эзгүй газар хөөж орхи гэв.

Ийм үгийг хэлж, Тэмүүжинийг Чингис хаан гэж нэрийдэж хаан болгов" гэж МНТ-д бичсэн тэр түүхт газрыг үзэх болно. Бидэнд ШУА-н түүх газар зүйн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан доктор профессор Базаргүр ярихдаа:

"-Төв аймгийн Мөнгөн морьт сумын Их хоригт ихэс дээдсийн шарил байдаг.Чингис хааныг бие барахад Хөдөө арлаас Хэрлэн голыг өгсөж 90 тэрэг ачаа гарсаны ихэнхийг Бунхант гэдэг газар аваачиж Чингис хааныг тэнд оршоосон болгож төөрөлдүүлсэн домог буй гэж ярьсан бөгөөд Чингис хааныг "Ихсийн газар буюу Өглөгчийн хэрэмд оршоосон гэж үзэж байгаагаа тэр газар дээр нь тайлбарласныг хойно өгүүлэх болно. Их хориг, Бунхант гэдэг газар бидний анхаарлыг их татдаг

*Д.Наянтай, Г.Батжаргал*

боловч, Ихсийн газар буюу Өглөгчийн хэрэмтэй адил нудээр үзээгүй болохоор хооронд нь харьцуулан бичих боломжгүй байна. Үүнээс гадна дээрх замаар явбал Чингис хааны амьдарч, шүтэж байсан Бурхан Халдун уул түүний ойролцоо орших хөшөө, дурсгал, булш, бунхан, түүх дурсгалт үзэсгэлэнт газрыг үзэж зураг авч, зурж, бичлэг хийх, судалгаа, тэмдэглэл хийх бололцоотой юм. Гэвч энэ зам нь өндөр уул даваатай, олон горхи гаталж явах машин зам үгүй тул газар мэдэх хүнээр газарчлуулан явган буюу мориор явахад тохиромжтой юм байна

### **Өглөгчийн хэрэм буюу Ихсийн газар**

Аяллын хоёрдах өдөр өглөө эртлэн босож есөн цагийн орчимд аяллын замд гарлаа. Бид энэ өдөр Хэнтий аймгийн Батширээт сумын нутагт байгаа Ихсийн газар буюу Өглөгчийн хэрэм хүрэх төлөвлөгөөтэй байлаа. Хэрлэн голын гүүрээс Ихсийн газар хүрэх хоёр зам байна. Эхний зам нь хэрлэн голын зүүн этгээдээр өгсөж 40 орчим км яваад Юдэгийн даваагаар давж Хурхын голын эх хүрч голоо уруудан явсаар Биндэрийн овоо хүрч тэндээс Ихсийн газар хүрэх зам байна. Нөгөө зам нь Хэрлэнгийн гүүрээс зүүн хойшоо 5 орчим км яваад Чулуут толгойн зүүн талаар зүүн хойшоо даваад зүүн хойноос урсаж Хэрлэн голд цутгадаг Жаргалантын голыг өгсөж 10 орчим км яваад голыг хөндлөн гарч хойд энгэрээр нь зүүн өмнө зүг их замаар явна. Энэ замаар 7 км яваад Жаргалантын голоо дахин хөндлөн гараад зүүн урагш эргэж нэгэн намхан даваагаар даваад Цэнхэрийн гол хүрнэ. Энэ голыг Цэнхэр мандал сумын төвийн баруун этгээдэд байгаа жижиг модон гүүрээр гарч сумын төв хүрнэ. Сумын төвийн баруун талын жижиг толгойн өвөрт байгаа ШТС-аас шатахуун нэмж авлаа. Хэрлэн голын гүүрээс энэ ШТС хүртэл 59 км буюу Дарханаас 432 км байна.

Цэнхэрмандал сумын төв нь Эх орны дайны үед /1941-1945онд/ Модотын уурхайн төв байсан бөгөөд энэ уурхай нь цагаан тугалга олборлон хүдрийн баяжмал бэлтгэн тэр үеийн нэрээр ЗХУ-д экспортлон гаргаж байжээ. Энэхүү уулын баяжуулах үйлдвэрт асар өндөр хучин чадалтай fabriкууд ажиллаж байсан байна.

Сумын төвөөс урагшаа гарч баруун талын тод замаар явна. Хэрэв зүүн замаар явбал 1940-өөд оны үед хүдэр олборлож

*Бөртэ хатны уугуул  
нутгаар* \_\_\_\_\_

байсан уурхай хүрнэ. Сумын төвөөс 3 км яваад нэгэн намхан даваагаар давна. Эндээс 10 орчим км яваад тэр орчимдоо нэлээд өндөр гэгдэх Хархираагийн даваагаар давна. Дарханаас Хархираагийн давааны орой хүртэл 457 км байна. Давааны ар талд /баруун гарт/ хус, хар мод холилдсон бэсрэг ойтой юм. Давааны ар тал руу /100 гаруй м/ их огцом бөгөөд борооны усанд зам нь идэгдсэн гуу жалга үүсэж эхэлж байна. Дараагийн аялагчид энэ даваагаар давахдаа болгоомжтой явах нь зүйтэй юм. Хархираагийн даваанаас зүүн урагш уруудаад 7 км яваад жижиг суурин байсан газарт хүрнэ. Энд барилга байшин, малын хашааны суурь байна. Цөөн хэдэн айл байх ба ихэнх нь өндөр настай хүмүүсээс гадна зуны амралтаараа өвөө эмээдээ ирж тугал хариулж байгаа хүүхдээс өөр хүн байхгүй байлаа. Суурингаас зүүн урагш их замаараа явахад байгалийн маш сонин өвөрмөц тогтоцтой хадан цохионууд байна. Энэ нь асар том боржин чулууг давхарлан хураасан мэт байв. Гэхдээ энэ бүхэн нь хүний гараар хийгдээгүй нь лавтай бөгөөд байгаль ингэж өөрөө бүтээнэ гэдэг үнэхээр гайхамшигтай юм.

Суурингийн төвөөс Өмнөдэлгэр сум хүртэл 41 км байлаа.

Бид өдрийн 12цагийн үед Өмнөдэлгэр сум хүрч аяны дөрөө түр мултлав.

Тус сумын ИТХ-н даргатай уулзлаа. Өмнөдэлгэр сумын төвийн баруун этгээдэд хэд хэдэн гол хөндлөн гарлаа. Хэрэв бороо хүр элбэгтэй үед бол энэ голуудыг машинаар гарахад нэлээд бэрхшээлтэй байж болзошгүй мэт байлаа. Дарханаас Өмнөдэлгэр сум хүртэл 510км байна. Сумын төвөөс зүүн хойшоо 3км яваад зам 2 сална.

Хэрэв баруун гар талын замаар явбал Гурванбаян сум дайрч Биндэр сум хүрнэ.

Энэ зам нь Ихсийн газар буюу Өглөгчийн хэрэм хүрэхэд бага зэрэг тойруу болно. Ийм учир бид зүүн гар талын замаар явж Хэнтий бригадын төвөөр явлаа.

Сумын төвөөс бригадын төв 25км байсан. Хэнтий бригадын төвийн өмнүүр Хурхын голын гүүрээр гарна. Төмөр гүүрийн дэргэд голынхоо баруун гарт нэгэн жижиг хонхорт зөөврийн уурын гал тогоо байлаа. Энэ нутгийн нэгэн хүн ярихдаа/...1950- аад оны эхээр манай сум анх энд байгуулагдахад сумын дарга

Матадын уурхайгаас том трактороор чирч авчраад энр голын эрэгт суурилуулж ажиллуулсан.

Эндээс манай сумын барилгууд халаалт авч байсан. Англи улсад үйлдвэрлэсэн гэж тэр үед яригддаг байсан гэж бидэнд хуучиллаа. Тэндээс Улаанбаатар Батширээтийн замд орж аяллаа цааш үргэлжлүүлж 44 км яваад Гурванбаян сумын Хурх бригадын малчин Сандагдоржынх гэдэг айлд хүрч аяны хоёр дахь хоногоо өнгөрүүлэв. Сандагдорж гуайнх Хэнтий аймгийн Батширээт сумын уугуул бөгөөд аяллын багийн гишүүн Д.Цэрэнхандын хамгийн том ахынх болох буриад айл байлаа. Хувьдаа хэдэн малтай товхийсэн амьдралтай, яриа хөөрөөтэй идэж уухаар элбэг дэлбэг авгай, баавай хоёр байлаа. Өвгөн алс холын аялалд яваа бидэнд хүндэтгэл үзүүлж эр хонь төхөөрч шимийн архиар дайлахад бид ч нутгаасаа авч гарсан бэлэг дурсгалын зүйлийг гардуулан өглөө. Эднийх Хурхын голын зусланд гарсан байв. Эндээс бидний зорьж яваа Биндэрийн овоо дүнхийн харагдаж байлаа. Биндэрийн овооны баруун гар талаас харахад /10 орчим км/ Д.Базаргүр, Д.Энхбаяр нарын "Чингис хаан төрсөн ба оршуулсан газар" номын 22-р хуудсанд зураг нь зурагдсан хэвтэж байгаа хун шувуу шиг сунаж тогтсон уул харагдана. Хүзүүгээ сунган хэвтэж буй хун мэт уулыг хараад Оюунцэцэг ийн дүрслэв ээ.

### **... Хулдгар хунг ажихуй:**

Алжаасан хун шувуу Амарч хэвтээ ч юмуу Алсын уулсыг ширтээд Анирлаж байгаа ч юмуу Зүүрмэглэгч хун шувуу Зүүдээ таагаач гэв үү Зуун зууны түүхийг Зүрхэн тушаагаа хадгална уу ... “ гэхүйд аялагчид бид байгаль орчны байршил, газар усны нэр, түүх домгийн уялдаа нь яруу найргийн хэлээр ямархуу гүн сэтгэгдэл төрдгийгбахархан ярьж эх түүхээ эрхгүй эргэн санагалзавай. 10 цагийн орчим Биндэрийн овоонд очлоо. Овооны эгц өмнө талд битүү зэгв хулстай жижигхэн цагаан нуур, нуурын эргэн тойронд

*Бөртэ хатны уугуул  
нутгаар*

---

үхэр мал багшран идээшлэнэ. Нууранд хос цагаахан хун алгуурхан хөвнө. Нутгийн олны дунд нуурын тухай нэгэн домог байх бөлгөө. Тэмүүжин Жамуха хоёрын найрлаж хоносон энэ газар хонхор болж хожим нуур тогтсон гэнэм. Энэ нуурнаас хос хоёр хун хэзээ ч салдаггүй ажээ. МНТ-116-д Тэмүүжин Жамуха хоёр Хорхунагийн хөндийд нийлэн бууж эртний анд бололцсоноо дурьдаж улам дотно найрамдъя гэлцэв гэсэн байх бөгөөд

“...Хорхунаг Жибурын хөндий

Хулдгар хуны өвөрт

Саглагар модны доор

Сайхан хуримыг үйлдэж

Сайтар бүжиглэн жаргаж

Санаа сэтгэл нэгдэн

Сайн нөхөд болоод

Шөнө нэгэн хөнжилд орж хонох бүлгээ ... /МНТ-117/ ”

гэж яруу тодорхой бичиж үлдээжээ. Тэрхүү бүжиглэж хоносон газар нь энэ цагаан нуур ч юм билүү гэж бид ярилцан авай "Амбагай хаан баригдаад Хадаан, Хотола хоёрын нэр заасан тул Хамаг Монгол Тайчууд нар Онон мөрний хөндий гэдэг газар цугларч хэлэлцээд Хоталыг хаан болгов. Монголын жаргалан нь бүжиг хурим бүлгээ. Хоталыг хаанд өргөмжлөөд хавирга газрыг халцартал, өвдөг газрыг өлтөртөл дэвхцэн бүжиглэж хуримлав.

/МНТ-57/ Мөн тэрхүү газар нь энд ч байхыг үгүйсгэхгүй. Биндэрийн овооноос баруун тийш Өглөгчийн голын өмнүүр баруун хойноос зүүн урагш чиглэсэн араараа модтой сайхан уулыг Биндэрьяа гэнэ. Буриад ардын дуунд:

"... Араараа модтой Биндэрьяа минь

Ар хурхын чимэг юм.

Алтан үсэггүй Монгол бичиг

Ард бидний чимэг юм ..." гэж өнө эртнээс дуулж ирсэн

ба энэ дууг Хан Хэнтий чуулга найрал дуу болгон дуулсан нь Монголын радиогийн алтан фондод хадгалагдан байдаг юм. Энэ уулыг Хунтай-Биндэр, Хулдаа-Биндэр, Хууцай-Биндэр гэх мэтээр эртнээс нааш нэрлэж ирсэн тухай Д.Базаргүр, Д.Энхбаяр нарын бичсэн "Чингис хааны төрсөн ба оршуулсан газар" номд дурдсан байдаг.

Биндэрийн овооноос баруун урагш буюу нуурын хойд энгэрээр нэлээд хэдэн булш байдаг. Чулуун зэвсгийн үеийн чулуун багаж, галт уулын хүрмэн чулуу ч энд тааралдаж байлаа. Овоос.оос зүүн тийш 200 орчим метр газар Рашаан хад гэж нэрлэгдсэн том боржин чулуун хад байна. Энэ хаданд маш олон тамга сийлжээ.

Энэ тамгийг Монголчуудын олон овгийн тамга гэх бөгөөд 400 орчим тамга бий гэж эрдэмтэд үздэг юм байна. Мөн эрдэмтэд энэ хадан дээр МЭӨ үеэс эхлэн олон хэл дээр бичсэн дурсгалт бичээсүүд бий. Монголоос өөр хаана ч нэг хадан дээр ийм олон тамга, олон үеийн бичээс, олон хэлээр бичсэн нь үгүй юм. Үүнээс үзэхэд энэхүү уул нь /Биндэр уулыг хэлжээГ.Б/. эртнээс шүтэж ирсэн тахилгат уул, голомт нутаг болох нь харагдаж байна гэжээ. Ухаант өвөг дээдэс минь хойч үедээ өөрсдийн хэрэглэж байсан тамга тэмдгийг хадан дээр сийлж үлдээсэн энэ дурсгалт зүйл нар бороонд элэгдэж,бүдгэрч мэргэжлийн биш хүний нүдэнд мэдэгдэхээргүй болж байгааг газар дээр нь хамгаалж цаашид судалж тодруулан тойрон аялагчид жуулчдын хүртээл болгох нь чухал санагдлаа.

Рашаант хадны талаар үзэж харснаа тодруулъя.

Энэ том хэмжээтэй боржин чулуун хадны урт нь 5-6 орчим метр, өндөр 2-2,5 м, зузаан нь 0,5-1,0 м бөгөөд хажуу ирмэгээрээ босоо хэлбэртэй байна. Энэ хад нь зүүн өмнө зүг буюу наран мандах зүгхаржээ. Энэ хадны ихэнх нь газарт шигдэж булагдсан байсныг ухаж гаргасан нүх одоо хэр нь арилаагүй байна. Энэ хадыг нэрт архилогич эрдэмтэн Хөдөөгийн / Дамдины/ Пэрлэй гуай анх олж 1960-аад оны эхээр малталт хийж илрүүлсэн юм байна. Энэ хадны баруун талд 5-6 метрийн зайтай өндөр /10 орчим метр/ хадан байц чулуу байна. Энэ хадан байцад тамгатай хадны хэмжээний хонхор байх нь хэзээ нэгэн цагт энэ хадан байцаас тамгатай чулуу байгалын ямар нэгэн шалтгаанаар тасарч унасан байж болзошгүй мэт байна. Энэ хадан байцны хонхорын дээд ирмэгээс ус дусалдаг бөгөөд үүнийг нутгийн хүмүүс нүдний рашаан гэж нэрлэдэг юм байна. Энэ жил гандуу байсан болоод ч тэр юмуу биднийг очиход ус дуслахгүй байсан. Энд ямар нэгэн хэмжээгээр ус дусалдаг байсан шинж тэмдэг харагдаж байсан. Ус дусалсан газарт нь хүрэн өнгөтөй зэв тогтсоныг үзэхэд энэ хаданд төмөрлөгийн

*Бөртэ хатны уугуул  
нутгаар*

---

элемент ямар нэгэн хэмжээгээр байж болох магадлалтай юм билээ. Эртнээс нааш рашаан хэмээн дээдэлж ирсэн энэ эрдэнэ мэт нандин байгалийн эмийг хамгаалж хайрлах нь юу юунаас чухал гэдгийг хүн бүр мэддэг сахидаг байсансан бол басхүү нэг талдаа дуссаар хүн бүрт хүртсээр л байх байсан юм биш байгаа гэсэн харуусал эрхгүй төрж байсан. Магадгүй их эзэн богд минь мэлмий юундаа дуслын төдий дусаагаад хэдэн бээрийн газрыг түүртэлгүй тольдон хардаг байсан болов уу хэмээн бодолхийлнэм.

Биндэр уулын орой дээрх овоог Чингис хааны тахилгын овоо гэх ба даваан дээрх овоог шарын шашны тахилгын овоо гэдэг юм байна. Эл бүхнийг харжээ зогссон манай аялагч Ч.Оюунцэцэг:

"Буурал дээдсийн өлгий нутаг

Буман үеийн өлзий хутаг

Чингис хаан Жамуха хоёрын

Чин зүрхний анд бололцсон

Хорхунаг жибурын өргөн хөндий Хулдгар хуны  
энэ л өвөрт

Өвгөдийн сургаалыг санан дурсаж Өндөр  
овоонд нь сөгдөн мөргөө

Эртийн эртнээс Биндэр уул Их сүрээр бүхнийг  
бишрүүлж Эдүгээ бидний үе хүртэлх Энгүй түүхийг  
хадгалж иржээ

Олон зууны тэртээх

Омгийн тамга энд сийлэгдэж Он оныг улиран  
элээсээр

Одоогийн бидэнд хүргэж өгчээ..." хэмээхүйд  
үнэхээр л их түүхийн өлгий дөө гэж санах ажгуу. Дарханаас  
Биндэрийн овоо хүртэл 604 км байна.

Рашаантын хаднаас зүүн хойшоо уруудаж буухад энэ зам  
хоёр сална. Баруун гар талын зам нь Хурхын голыг уруудсаар  
Биндэр сум хүрэх бөгөөд зүүн гар талын зам нь Батширээт сум  
хүрнэ. Энэ зүүн замаар 8 км яваад мөн зүүн талаас орж ирэх  
Өглөгчийн голын араар тойрч голын хойд энгэрийн замаар

"Ихсийн газар буюу Өглөгчийн хэрэм" хүрэх нь бартаа саад багатай санагдав.

Бид замдаа 73 настай Няндаг гэдэг өвгөнтэй уулзав. Няндаг гуайн өвөг удам эртнээс Ихсийн газрыг хамгаалж, харж тэр орчимд өвөлжиж нутаглаж иржээ.

Дээдсийггоршоосон Өглөгчийн хэрэмд хүн мал оруулдаггүй, баруун өндөр дээр нь том ширмэн тогооны хагархай малын яс элбэг байдаг. Тайлга тахилга хийж байсны үлдэгдэл байх гэхчилэн ярьсан бөгөөд 1973 оны 7-р сарын 23-нд үдээс хойш зурвас газар хүчтэй салхи хөдөлж машин хийсгэж рамыг нь гэмтээсэн, хүн нас барсан тухай, аянга цахилгаантай цагаан тоос тэнгэрт боссон байснаа Хараат уулын чиглэлд гол руу ороод замхарсан тухай хуучлав.

Сонирхолтой нь удам дамжин хамгаалж ирсэн Няндаг гуайнхаас өөр айл буухаар хоосроод байдаг харин энэ айлын мал өсөөд байдаг гэсэн нэгэн яриаг зам зууртаа сонсоод бид хоорондоо гайхан ярилцаж явлаа.

Өглөгчийн голыг гатлахдаа баруун талын намгархаг хөрсөнд сууж мод чулуу, дамнуурга хэрэглэн хялбархан гарсан нь монгол бүсгүйчүүдийн авхаалжтай, гялалзуур басхүү ажилсаг гэдгийг харуулсан. Цангинатал инээлдэж байгаад машинаа түлхэж байхыг харсан эрчүүд бид ч хүч орох шиг болсон шүү. Машин суусан зам мөрийг харсан ч дараагийн аялагч зорчигчид Өглөгчийн голыг хөндлөн гарахдаа болгоомжлох хэрэгтэйг сануулья.

" Өглөгчийн хэрэм нь Хэнтий нурууны өвөр талын шувтарга болох Биндэръяа уулын араар урсах Өглөгчийн голын хойд энгэрт Өргөн Банзат уулын зүүн урд наран эзвэр энгэр газарт оршдог/3/. Хэрмийг хүчирхэг улсын их хаан олон цэргийн хүчээр /10000 хүн/өдөр/ бариулсан том бүтээн байгуулалт тул дэлхийн зарим хаадын оршуулгын газартай эн зэрэгцэх ажээ. Өглөгчийн хэрмийн өмнө талын хаалга байсан бололтой зайны өмнөхөн "Өглөгчийн хэрэм бол Ихсийн газар мөн гэсэн дурсгалын багана босгосон байна.

Хэрмийн хана дунджаар 3-4 м өндөр.эргэн тойрон 3.2 км 1000 га талбайг эзлэнэ. Чулуун хэрмийн дотор талаас шороогоор манаж бэхэлсэн байх бөгөөд энэ их шороог авсан гуу жалгаар морьтой явган ердийн хөсгөөр явсан ч харагдахааргүй байсан

*Бөртэ хатны уугуул  
нутгаар* \_\_\_\_\_

нь шарилыг чухам хаана оршоосныг нууцалж байсан нэг арга гэж Базаргүр доктор ярьж байлаа. Тэр шуудуу одоо бараг мэдэгдэхгүй шахам болсон байв.

100-аад метр яваад Чингисийн тахилгын овоо гэж нэрлэгдсэн Байгалийн ургаа байц хад байх бөгөөд түүнийг тойруулж чулуу өрсөн нь тахиж шүтэж онцолж байсныг илтгэнэ. Энэ чулуун овооны ар талд нэлээд өндөр сэнжтэй хад байх бөгөөд Чингисийн морины уяа гэсэн домогтой юм байна. Уулын бэлээс оройг харахад хоёр метр орчим өндөртэй гурван босоо хадан дээр хөндлөн хад тавьсан нь түүний хэтийсэн чигт газар ухвал дээрээс унах гэж байгаа юм шиг харагдсан бөгөөд нэг жилийн өмнө ирэхэд хэлтийж байсан нэг тулгуур чулуу нь унасан юм шиг санагдаж билээ.

Эдгээр чулууг түүний дор нууцалсан бунханг хамгаалах зорилгоор өндөр оргил дээр байршуулсан байж болох ч юм гэж санагдаж байлаа.

Өглөгчийн хэрмийн өндөрлөг газарт харуулын байр байгаа нь энэ газар харуул хамгаалалттай байсныг илтгэх бөгөөд хиймэл далан нууц замын төгсгөлийн дээд талд ширмэн тогооны хагархай малын яс элбэг байсан нь энэ байгууламжийг байгуулах үед болон тахилга тайлга үйлдэхэд хэрэглэж байсан зүйлийн үлдэгдэл гэж яригдаж иржээ.

Биднийг ийн үзэж сонирхож биширч байх ахуйд доктор профессор Базаргүр "-Та нар Ихсийн газар хэмээх энэ газарт ирээд Өглөгчийн хэрмийн дотор ороод зогсож байна. Та бүхэн Монгол туургатны буурал түүхийн нэгэн онцгой энэ газрыг үзэхээр хэдэн зуун км зам туулж ирсэнд баярлалаа. Энэ газрыг үзэхээр эмэгтэйчүүд эхчүүд зорьж ирсэн нь бүр ч сайшаалтай болж " гэв.

Өглөгчийн хэрмийн хойт талын энэ өндөр хадан цохио нь далайн төвшнөөс дээш /дтд/ 1400 м өргөгдсөн, урд талын энэ хэрэм байгаа хэсэг нь дтд 1260м-т байдаг.

Хэрэмний нүүрэн талын урт нь 500м, зүүн талаараа тэр харагдах уулын хяр даган БООм, баруун ба баруун хойт талаараа мөн та бүхэнд харагдаж байгаа ханан байц хад цохиогоор дамжсан 3.52 км-ийн урттай чулуун хэрэм юм. Хэрмийн өндөр 3-4 м байдаг. Зарим газраа нурсан хэсэг ч бий.

Хэрмийн дотор байгаа жижиг хиймэл толгой, хэрмийг дотор талаас нь тулж бэхэлсэн шороон далан зэргийг үндэслэж газрын доор ямар нэгэн байгууламж, ихсийн бунхан байх магадлалтай гэж б. (үзэж байгаа. Бидний байгаа энэ хадан цохиог Чингисийн тахилгын овоо гэдэг. Бидний дэргэд байгаа эдгээр чулуун овоо модонд аянга олон удаа бууж, хэсэг хэсэг газар мод шатсаныг харахад эдгээр газарт ямар нэгэн "металл" байж болох юм. Бидний урьдчилж авсан шинжилгээний материалын дүнгээс үзэхэд 60 гаруй булш нь оршуулсан байршил, хэлбэр эрэмбээрээ Монголын их хаадыг нууцалж оршуулсан булш мөн гэж бид үзэж байгаа.

Чингисийн төрсөн газрыг Биндэр сумын төвийн өмнөх Ламын ухааг Ононы Дэлүүн болдог мөн гэж үзээд бид өнгөрсөн жил дурсгалын багана босгосон гэж тэрээр ярив.

Богд Жавзандамба хутагт энэ нутгийг нууцаар зорин ирж тахилга хийж өргөл өргөж байжээ. Тухайн үед Биндэр ууланд ойрхон байсан 1000-аад ламтай Бэрээвэн хийдийнхэн Богд Жавзандамба ирэх байх гэж бэлтгэж байсан боловч очоогүй гэдэг.

Жавзандамба хутагтын алс холоос очиж хийсэн энэ үйлдэл нь Чингэс хааны онгонд тахилга өргөж мөргөл үйлдсэний баримт болов уу гэж доктор профессор Базаргүрийн бичсэн номд өгүүлжээ/3/.

Биднийг энд байхад хэрмийн хашааны суурьд малталт хийж байгаа архелогичид ч тааралдаж байв.

Өглөгчийн хэрэм бол түүхийн олон нууцыг тайлах оньсон түлхүүр газар мөн гэдэгт эргэлзэхгүй байна/Г.Б/. Ямартаа ч гэсэн ихэс дээдэс хаад ноёдын шарил бунхныг хадгалсан энэ нутаг өөрийн нууцыг дэлгэж судлаачид аялагчид хойч үеийнхний үзэж харах тахиж шүтэх газар болох цаг удахгүй мэт санагдах авай.

Эндээс хөдлөхийн өмнөхөн Оюунцэцэг маань:

Элгээ дэвтээж өсгөсөн  
Ээжийг минь бодогдуулна  
Энгэрээ дэвсэж эрхлүүлсэн  
Эцгийг минь санагдуулна  
Их эзэн Богдын маань  
Эгэлгүй өлмий тамгалсан

*Бөртэ хатны уугуул нутаг* \_\_\_\_\_

Эрхэм бүхэн оршсон  
Ээ дээ...сүслэмээр нутгаа

Дуун алдаж бахадмаар  
Дугараа өргөн хүндэлмээр  
Энэ л сайхан хангай

Эх орны минь голомтоо  
Буурал дээдэстээ залбирч  
Бууж тухлан сөгдөө  
Буян заяа өршөөхийг

Бүгдээрээ гуйж мөргөө гэхүйд хөх тэнгэр хөрст  
дэлхий, уул овоондоо идээ будааныхаа дээжийг өргөн Чингисийн  
тахилгын овоонд хадаг дэлгэн цааш аяллын замаа үргэлжлүүллээ.

Ихсийн газар буюу Өглөгчийн хэрэм дотор дурсгалын  
зурагнууд татуулан байхдаа байгалийн бишрэм дүр төрх эгээ л  
хүний гараар цогцлоосон мэт байдлыг харахад энд Монголын  
дээдсийн шарилыг онголсон байж болох нь жирийн аялагчид  
бидэнд ч мэдрэгдэж байлаа. Энэ дагшин өлгийд Монгол хүн бүр ирж  
эцэг өвгөдийнхөө ариун онгон шүтээнд бишрэн мөргөх цаг тун  
удахгүй гэдэгт итгэж байнам.


Ихсийн газраас зүүн урагш 10 км орчимд байгаа 2 буган  
хөшөөг үзэж сонирхов.

Энэ хөшөөний дээд хэсэгт нарыг дүрсэлсэн бололтой гурван  
дугуй дүрсийг хооронд нь холбосон нь өмнө үзэж байсан буган  
хөшөөнд тааралдаагүй сонин санагдана. Эндээс бид хөдөлж  
Биндэр сумын өмнө талд цагаан нуурын ард Монгол - Америкийн  
“Чингисхаан” судалгааны ангийн босгосон /1206 онд Чингис хаанаар  
өргөмжилсөн газар /гэсэн баганыг үзлээ.

Тэр газраас зүүн урагш километр орчим яваад /Чингис хааны  
төрсөн Ононы дэлүүн болдог/ гэсэн уйгаржин монгол бичигтэй  
багана дээр очсон билээ.

Биндэр сумын төвд 1937-1938 онд улс төрийн хилс хэрэгт  
хэлмэгдэгсдэд зориулан босгосон гэрэлт хөшөө байх бөгөөд  
хөшөөний суурь дээр :

"-Амьдралын чинь үргэлжлэл ач үрс чинь сэтгэлээ дэвсэж  
бүтээв."Тэж бичсэн байлаа.




*Дархан-Уул аймгийн “Хаан-хатан”  
сүйх бүхий, сүлдэт тэмдгийн дэргэд  
Аялалд гарахын өмнө  
2002 он*



Хэрлэнгийн  
 хөдөө аралд  
 Аварга тосон нуурын  
 урд энгэрт  
 “Өгөдэйд хаанд  
 өргөмжилсөн газар”  
 хэмээх тэмдэг  
 босгожээ  
 2002 он





Улаанбаатар  
хот дахь Чингис  
хааны нэрэмжит  
“Их засаг”  
Их сургуулийн  
дэргэд тойрон  
аялагчдад  
хүндэтгэл үзүүлэв







Дадал сумын төвийн ойролцоо  
“Дэлгун болдог Чингис хаан усан морин жил 1162 оны  
зул сарын 16-нд энд мэндлэв” гэсэн бичээсийн дэргэд  
2001 он



Дорнод аймгийн төвд Чингис хааны төрийн их хатан  
Бөртэ Үжиний хөшөөний суурь тавьж байгаа нь  
2002 он



*Рашаантын хадны төрөл бүрийн бичээс*




*400 гаруй тамга сийлэгдсэн хад*



*Хэрлэнгийн гуурний зүүн талд, хөдөө аралд буй  
Чингисийн онгон явах замыг заасан тэмдэг  
2001 он*



*Хулдгар хун уулын "Биндэрийн овоо"  
2002 он*



1937-1938 онд улс төрийн хэргээр Биндэр сумаас  
баривчлагдан хэлмэгдсэн хүмүүст зориулж сумын төвд  
босгосон хөшөөний нүүрэн талд нь:

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн гэгээн дурсгалд  
суурин дээр нь:

“ Амьдралын чинь үргэлжлэл ач үрс чинь  
сэтгэлээ дэвсэж бүтээв ” гэж бичжээ



Хэнтий аймгийн  
Биндэр сумын нутаг  
Онон хурхын голын бэлчир  
Цагааннуурын хойд хөвөөнд  
“1206 онд Чингис хаанаар  
өргөмжилсөн газар”  
хэмээн бичиж босгосон багана  
2001 он





Хэнтий аймгийн  
 Биндэр сумын нутаг  
 Онон Хурхын  
 голын бэлчирт босгосон  
 “Чингис хааны төрсөн нутаг”  
 Дэлүүн болдог”  
 гэсэн бичигтэй багана  
 2001 он





Хэнтий аймгийн  
Батширээт сумын  
нутагт орших  
Ихсийн газарт  
байгаа Чингисийн  
тахилын овоо



*Өглөгчийн хэмээх чулуун хэрэм*




*“МНТ-нд бичигдсэн Ихсийн газар  
Чингис хаан экспедиц” гэсэн багана босгосон урд тал*



Цагаан-Овоо сумын  
төвд босгосон улс төрийн  
хилс хэрэгт хэлмэгдэгсдийн  
дурсгалд зориулсан  
“Залбирал” хөшөө  
2002 он





Дорнод аймгийн Цагаан-Овоо сумын төвд байгаа  
Халхын “Хэцүү То Ван” хэмээх Тогтохтөрийн  
морины чулуун уяаны дэргэд  
Зүүн гараас: Г.Батжаргал хэсэг нөхдийн хамт  
2002 он





МНТ-ны 750 жилийн  
ойгоор Хэрлэнгийн  
хөдөө аралд босгосон  
Чингис хааны гэрэлтн  
хөшөө, Их Монгол Улсын  
анхны нийслэл аураг  
/шар орд/ хотын  
тнуурийн дэргэд  
Чингис хааны онгонд  
сүндэрлэж байна.






Улаанбаатар хотын  
урд талд орших  
Дархан цаазтай Богд хан  
уулын Хүрэл тогоот дахь  
одон орныг судлах төвд  
2002 он





*Эртний  
Хэрлэн бар хотын  
туурьт үлдсэн 22м  
өндөр харуулын  
цамхаг*



*Дорнод аймгийн төвд байгуулсан Халх голын байлдааны  
ялалтад зориулсан хөшөөний цогцолбороос*

*Д.Наянтай, Г.Батжаргал*

Онон голыг Биндэр сумын төвийн зүүн хойно байгаа гармаар гарлаа.

Монголчуудын дунд хамгийн өргөн дэлгэрээр ойлгогдсон Дэлүүн болдог нь Дадал сумын Гурван нуурын рашаан амралтын төвийн гурван нуур юм.

Дадал сумын төв далайн түвшнээс дээш 980 м байдаг нарс модон ойтой үзэсгэлэнт сайхан нутаг юм. Бидэнд ахмад багш Г.Цэрэндорж өмнөх жилийн аяллын үед дэлгэрэнгүй тайлбарласнаас товч танилцуулъя.

Рашаан амралтын төвд байгаа дунд нуурын голд нэгэн жижиг арал байсныг машинаар чулуу зөөж нэмж өндөрлөх гээд бүр живүүлсэн гэнэ. Энэ нуурын хойд талд Чингис хааны мэндэлсний 800 жилийн ойд зориулж босгосон сүрлэг сайхан хөшөө байна.

Энэ хөшөөг алсаас харахад босгоод тавьсан зүрх мэт хэлбэртэй байгаа нь их эзэн хааныг үхэлгүй мөнх хатан зоригтон гэдгээр нь дүрсэлсэн гэж бодогдоно. Тод цагаан өнгөөр хөшөөг өнгөлсөн нь монгол хүний ашдын билэг сүүн цагаан сэтгэлийг илэрхийлжээ. Хөшөөний өндөр 10-аад метр, өргөн нь 5-6 м орчим. Нүүрэн талд эзэн хааны босоо зогсож буй хөрөг байх бөгөөд баруун дээд хэсэгт нь хар цагаан сүлдний гурван үзүүртэй хэсгийг дүрсэлжээ. Хөшөөний зүүн доод талд:

“Алд бие минь алжааваас алжаатугай

Ахуу төр минь бүү алдартугай”

гэсэн үгийг уйгаржин монгол бичгээр сийлсэн байна. Баруун доод талд “Чингис хааны мэндэлсний 800 жилийн ойд зориулж босгов. Монгол улсын төр” гэжээ. Хөшөөний дөрвөн өнцөгт морины дөрвөн туурайг баримлаар хийсэн байна. Хөшөөний өмнөд талд чулуун овоо байх бөгөөд өнгө өнгийн хадаг идээ будаа өргөсөн харагдана.

Хөшөө барих ажлыг Махбал гэдэг хүн ахалж гүйцэтгэжээ. Чингис хааны мэндэлсний 800 жилийн ойг тэмдэглэж хөшөөг босгох ажлыг МАХН-ын Төв Хорооны нарийн бичгийн дарга асан Д.Төмөр-Очир хариуцаж гүйцэтгэсэн байна.

Энэ хөшөөг хариуцаж босгосон академич Дарамын Төмөр-Очирын 80 насны ой 2001 онд тохиож, Д.Төмөр-Очирын амьдарлынхаа сүүлчийн жилүүдэд сууж амьдарч байсан Дархан

*Бортэ хатны уугуул  
нутгаар*

---

хотын 6-р багийн нутаг дэвсгэрт харъяалагддаг 16-р байр / Шинэ Дарханы хуучин хорооллын/ -ны хананд дурсгалын самбар байрлуулах ёслолын ажиллагааг 2002 оны 5-р сарын 21-нд аймгийн Ахмадын Хороо санаачлан зохион байгуулсан Энэ самбар дээр Дадал сумын Гурван нуурт байгаа хөшөөний ерөнхий дүрс /контур/-ийг зурж дүрсэлсэн байдаг.

Дадал сумын баруун хойд талын жижиг өндөрлөг дээр чулуугаар гэрэлт самбар босгож дээр нь "Дэлүүн-болдог, Чингис хаан-морин жил 1162 он" гэж бичжээ.

Эндээс холгүй орших Хажуу булгийн усан дээр очлоо.

Г.Цэрэндорж багш Монголын нууц товчоонд гардаг Зээрэн хавцал, эр хоёр загал морины нутаглаж байсан газар, Чингис хааны тамгыг сийлсэн хаш чулуунаас үлдсэн чулуу байдаг газрын тухай ярьж танилцууллаа.

**Хоёр: Бортэ хатны уугуул нутгаар...**

Дадал сумын өмнөх ШТС-ын өмнөх битүү нарсан ойтой, элстэй жижгэвтэр толгойн энгэрээр баруун урагшаа давж зүүн гарлуугаа эргэн өмнө зүг чиглэн явлаа. Эндэхийн зам маш олон салаа боловч бид Гол зам буюу холбооны шонгын мод дагасан замаар яваад Онон гол дээр тавьсан гүүр хүрлээ. Энэ гүүрийг 1990-ээд оны дундуур барьж ашиглалтанд оруулсан гэх ба 200 метрийн урттай төмөр бетонон гүүр байна. Энэ гүүрийн 18м-ийн уртай төмөр бетонон дам нурууг Гүүр барилгын ангийн дарга, инженер Чоймбал хээрийн аргаар цутгаж угсарсныг хэдэн жилийн өмнө төвийн нэгэн хэвлэлээс уншиж байснаа санаж, тэр төмөр дам нурууг үзэж сонирхлоо. Энэ их байгууламжийн үлдэц суурийг үзээд монгол хүний, монгол инженерийн агуу их ур ухаан, техникийн өндөр боловсрол, чадавхи энэ бүхэнд биширч явлаа.

Ер нь 12-18м-ийн урттай хүнд даацын төмөр бетон дам нурууг хээрийн аргаар, өндөр маркын бетон зуурмаг үйлдвэрлэж хийнэ гэдэг бол хэн дуртай хүний санааны зоргоор хийдэг ажил биш л дээ. Үүнийг хийж чадсан монгол ажилтнуудад баярлаж, манай орны томоохонд тооцогдох Онон гол дээр энэ сайхан гүүр тавигдсанд хаа холоос аялаж яваа Дарханчууд бид дахин баярлаж гүүрэн дээр сууж үдийн цайгаа уулаа. Энэ газрын үзэсгэлэнт сайхан байгаль, олон төрлийн шувуудын жиргээ, дуу

*Д.Наянтай, Г.Батжаргал*

авиа, усны урсгалын сонин гоё хөг аялгуу энэ бүхнийг магтаж хэлэх сайхан үг олдохгүй байлаа. Аялагч хатадын сэтгэл нэн өндөр байгаа нь илт харагдаж, бүтэн жилийн алжаал ядаргаагаа тайл < шиг санагдав.

Аймгийн Эмэгтэйчүүдийн Холбооны төслийн менежер Оюунцэцэг сэтгэл нь нэлээн хөдлөж өөрийн бичсэн нэг шүлгийг энэ нутгийн хөх тэнгэр, хөрст дэлхий, өргөн сайхан Онон голдоо зориулж уншив.

Шугуйдаа шувуудтай Ононгийн гол  
Шуугин шаагин урсанхан байна  
Шүлэг шиг яруу миний монгол  
Сүүдэргүй сэтгэлд яруухан байна.

Энгэртээ түүхтэй өлгий минь  
Ээвэрхэн агаад налгархан байна.  
Энд л суугаад үдлэхийн цагт  
Эрхгүй жаргалыг мэдрэнхэн байна.

Найман хатадтай бидний аялал  
Намсрай морилсон шиг тансагхан байна.  
Наргиантай найрагтай аяны зам  
Наян настны буян шиг байна.

Хан-Хэнтийгээс эхтэй гурван голын нэг, эзэн богд Чингисийн уугуул нутаг ундаалсан ус Онон мөрнийг усаар ч, гүүрээр ч ганцхан хоногийн хугацаанд хоёр удаа гатлаж байгаадаа баярлан идээний дээж Дархан нэртэй сархадаас гурвантаа сэржим өргөөд аялалаа үргэлжлүүлэхээр хөдлөв.

Дадал сумын ШТС-аас Ононы гүүр хүртэл 23км байлаа. Биднийг гүүрэн дээрээс хөдлөхөд эргэн тойрон борооны зузаан хар үүл гарч, энд, тэнд тэнгэр дуугарч, зарим үед цахилгаан гялбаж байлаа. Бид холбооны шонгын мод дагасан замаар явсаар Улз голыг мөн шинэхэн барьсан төмөр бетон гүүрээр гарлаа. Ононгийн гүүрээс Норовлин сумын төв хүртэл 44 км байна.

Эндээс Цагаан-Овоо сум хүртэл хоёр зам байна. Эхний зам Баян-Уул сум дамжин сайжруулсан шороон замаар явах, эсвэл Түмэн хан уулын баруугаар эрдэнэ гүний хийдийн суурь

дамжин самбарын талын тариан үтрэм дайраад Цагаан-Овоо хүрнэ. Энэ өдрийн үдээс хойш тэнгэр муухайрч их манан будан татаж холын бараа харагдахгүй шахам байлаа. Бид Түмэн-хан уулын баруугаар Самбарын тарианы үтрэмээр дамжин Цагаан-Овоо сум хүрлээ.

Манай аялалынхан 6-р сарын 24-ны орой Цагаан-Овоо сум хүрч, сумын төвийн иргэд, хөдөлмөрчидтэй уулзахаар төлөвлөсөн байсан учир сумын тамгын газрын ажилтнууд зохион байгуулалтын арга хэмжээ авсан байлаа. •

Цагаан-Овоо сумын Ахмадын хороон дарга Г.Батболд болон тамгын газрын ажилтнууд биднийг халуун дотно хүлээн авч тамгын газрынхаа буудалд байрлуулж, халуун хоол цайгаар дайлж сумын сайн дурын уран сайханчид концертоо тоглож үзүүлэв. Буриад хүмүүс холоос ирсэн зочин гийчинд дуу хуурын дээжээ өргөж, наргиж нааддаг нэгэн ёс байсан юм байна. Аялалд оролцож яваа хатад эмэгтэйчүүдэд зориулж буриад ардын олон сайхан дуу дуулж, ёохор бүжиг хатирав. Энэ сумын малчин залуу Г.Содномпунцаг, саальчин Балжирмаа нарын дуулсан дуу болгон манай аялагчдын зүрх сэтгэлд хоногшин үлдлээ.

Бид Дархан-Уул аймгийн эмэгтэйчүүдийн холбооны дурсгалын бичиг, морин хуурыг сумын соёлын төвийн даргад барилаа. Энэ суманд хүний их эмчээр тасралтгүй 37 жил ажиллсан их эмч Чимэдийн Батчулуун, бага эмч Цэвэгжавын Лоор нарт Эмэгтэйчүүдийн Холбооны ажилтан О.Болормaa дурсгалын зүйл гардууллаа.

Сумын тамгын газрын дарга Г.Батболд сумынхаа орон нутгийг судлах музей.ахмадын өргөө зэргийг үзүүлж тайлбарлав. Ахмадын өргөөг гэр хэлбэртэй барьж тохижуулжээ. Мөн 18-р зууны үед амьдарч байсан Монголын соён гэгээрүүлэгч халхын хэцүү То вангийн морины уяа болох дөрвөн талд нь сийлбэрлэн урласан боржин чулууг Халх голоос авчирч байрлуулжээ.

Тэр өргөөний зүүн өмнө 1930-аад онд энэ сумаас улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдэд зориулж 1995 онд босгосон “Залбирал” нэртэй зэс хөшөө босгожээ. Энэ сумаас л гэхэд 500 шахам хүн баригдаж цөөн хэдэн хүн 10 жилийн ял эдэлж бусад нь ялын дээд хэмжээгээр харамсалтайгаар хэлмэгджээ.

*Д.Наянтай, Г.Батжаргал*

Хэлмэгдлийн хар шуурганы гашууныг мартаж болохгүй сэрэмжлэх ёстой гэсэн харуусал гүнээ төрөх авай...

Сумын ЗДТГ манай аялагчдад зориулж Гүнцэнгэлэгийн нуурын дэргэд нэг өдрийн зугаалга зохион байгуулж, энэ зугаалгад сумын ахмадын, эмэгтэйчүүдийн төлөөлөгчдийг оролцууллаа.

Сумын Тамгын газрын дарга, ахмадын хорооны дарга Г.Батболд, төрийн бус байгууллага /ҮЭийнАийн ахмад ажилтан Л.Базаррагчаа нар нутаг орныхоо тухай олон сонин сайхныг хуучлан ярих. Тэд ярихдаа:

-...Есүхэй баатар Хонгирадын Дай-сэцнийд сүй тавиад буцах замдаа Цэгцэрийн шар талд нутаглаж байсан Татаруудын найранд бууж эртний өс санаж хоолонд нь хийж өгсөн хоронд хордож гурван хоног явж Онон гол хүрч нас эцэслэсэн тухай МНТ-д бичигдсэн байдаг.

Есүхэй баатарын явсан замыг доктор Д.Базаргүр, Д.Энхбаяр нарын 1998 онд "Чингис хаан" атласт зурахдаа Гүнцэнгэлэг нуурын хойт хөвөөгөөр, одоо бидний сууж байгаа энэ дэнж дээгүүр явж өнгөрснөөр зурсан байдаг юм. Ер нь Цэгцэрийн шар хээр гэдэг газрыг Яхийн нуураас зүүн урагшаа, Чойбалсан сумын төвөөс зүүн хойшоо байна гэж үзвэл энэ л замаар ирэхээс өөр газар байхгүй. Яагаад гэвэл халуун зунаар хазаар, морьтой хүн ус гол заавал бараадаж явахаас өөр аргагүй. Тэгвэл Яхийн нуурын араар орж Бальж гол өгсөж, Могойн голоор орж, могойн даваагаар давж, Улз гол хүрнэ. Улзын голыг өгсөж эхээр нь Сайхны голыг хөндлөн гарч, Шуусын голын /боохоор/ Онон гол хүрнэ. Бид их эзэн Чингис хааны эцэг Есүхэй баатарын явж байсан тэр газар сууж байна. Магадгүй энэ булаг рашаанаас амсаж байсан ч юм билүү гэж хуучлав.

Чингис хааны нэртэй холбогдолтой газрууд ч манай суманд бий.

Эндээс 30 гаруй км-ийн цаагуур "Чингисийн далан өнгөрдөг. Дайцэцний Цотон Бөртэ үжнийг Тэмүүжинд хүргэхээр явахдаа Хэрлэн голыг өгсөж явсан байх. Тэгвэл манай сумын өмнөд хэсгээр Хэрлэн гол урсаж өнгөрдөг гэх мэт олон сайхан түүх хүүрнэв. Түүхээ мэднэ гэдэг үнэхээр сайхан юм.

Гүнцэнгэлэг нуурын хойд эрэг дороос маш хүйтэн устай сайхан булаг оргилж нуурт орж байлаа. Ингэж л Дорнод аймгийн

*Бөртэ хатны уугуул  
Нутгаар*

---

Цагаан-Овоо сумынхан угтаж, Дарханы Хатад-эмэгтэйчүүдэд хүндэтгэл үзүүлсэн юм. Энэ сумынханд зориулж Оюунцэцэг:

Буриад нутагт айлчлахуйд  
Мэнд амар байна уу  
Миний буриад зон минь ээ  
Энх амар байна уу  
Элгэн буриад зон минээ

Уул уулыг даваад  
Ус голыг гатлаад  
Сэтгэл юугаа тээгээд  
Итгэл юугаа өвөрлөөд

Үүх түүхээ ярилцаж  
Өнийн явдлыг хүүрнэлдэхээр  
Түмэн бээрийн алсаас  
Түүртэлгүй явсаар ирлээ бид

Дуудах нэр нь Цагаан-Овоо  
Дуулдаг дуу нь Заяа-Наваа  
Мэхийн золгохдоо "Мэнд-Амар"  
Мөргөж сүслэхдээ "Хөх Тэнгэр"

Гүн хүндэтгэл  
Гүнзгий бишрэл төрүүлсэн  
Тал шигээ талбиун  
Тайван налгар зон танаа мөргөм үү

Аялгуут дуу, айзамт шүлгээрээ  
Аяны дөрөөг минь мялааж  
Цайлган сэтгэлээ дэлгэн угтсан  
Цагаан-Овоогийн зон гэвээс

Хун шувуун гарвалтай  
Хус модон цэрэгтэй  
Бөө мөргөлийн шүтлэгтэй  
Бүтэн заяатай түмэн байна.

*Д.Наянтай, Г.Батжаргал*

Үлдсэн ганц энэ барилга нь харуул хамгаалалтын цамхаг байсан бололтой орой дээрээ тал талруугаа харсан цонхтой барьсан юм байна.Эргэн тойрон алсуур хэрмийн туурь далангийн ор, баруун талаар нь арай тод мэдэгдэнэ.

Харуулын цамхаг 11-р зууны үед боссон бөгөөд өндөр нь 22 метр юм байна.

Энд ойролцоо нутаглаж байсан Балжирын Галсанжамц гэдэг айлд хоноглов.

Гэр бүл нь Түдэвийн Цэрэнханд гэх агаад 11 хүүхэдтэй өнөр өтгөн айл ажээ.

Бид энэ айлд морин хуур дурсгалаа. Галсанжамцынх Дархан-Уул аймгийн Эмэгтэйчүүдийн Холбоонд охин даага бэлэглэсэн нь өсөн үржихийн өлзийг ерөөсөн хүндэтгэл бөлгөө.

Монголын нууц товчооны төгсгөлийн 282-р бүлэгт “Их хуралдаан болж, хулгана жилийн /1240/ хуран /7-р/ сард Хэрлэний хөдөө арлын Долоон болдог, Шилхэнцэг хоёрын завсар хаан орд бууж байхад бичиж төгсөв” гэсэн Дэлгэрхаан сумын нутагт орших тэр л газарт сэтгэл яаран очлоо.

Монголын нууц товчооны 750 жилийн ойд зориулан босгосон Чингис хааны хөшөөний дөрвөн талд Рашаантын хаданд сийлж үлдээсэн 400 гаруй тамганаас тодруулан товойлгосон байх агаад мөн Чингис хааны онгоны том гэрт буй алтан шармал баримлын араар татсан цагаан хөшиг дээр ч тэр л тамганаас авч тодруулсан байлаа. Их Засаг Их сургууль, Хүннү ХХК-аас Чингис хааны онгоныг байгуулж, өсөн хөлт цагаан туг, хараа ихт хар тугийг мандуулжээ.

Хар санаа өвөрлөгчдийг  
Илд болон чичрүүлтүгэй  
Халуун монгол элэгтний  
Сүлд болон мандтугай

Өмхий элэг өвөрлөгчдийг  
Аянга болон ниргэтүгэй  
Үнэнч халуун сэтгэлтний  
Түшиг болон сүндэрлэтүгэй

Бөртэ хатны. уугуул  
нутгаар

---

Хамаг монголын сүлд болсон  
Хараа ихт туг минь ээ  
Гүр шувууны дэвэлтээр  
Гүн тэнгэртээ дүүлүгэй

Халдах догшин дайсны  
Халуун цусаар хооллотугай  
Хатан зориг эрчүүдийн  
Магнай дээр нь мандтугай гэж Чингис хааны догшин хар  
хөлт оронгийн их туг сүлдийг үйлдэн байгуулахад 10 бүгээн  
азаргын хар гөхөл дэл авчирсан тэр отго хүрээнийхнийг "Хар  
дэлийнхэн" гэж нэрлэсэн домогтой юм байна. /8-ийн 24-р тал/

Бид Аурагийн рашаан дээр ирлээ.Чингис хаан Аврага  
тосонгийн рашаантай нуурын хүч чадлыг үнэлж Энэ нуурт эр  
хүний эрхий бүү хүргэ, эмээлт морины туурай бүү хүргэ "гэсэн  
байдаг. Утга нь хүний биеийг нялхруулан тамирдуулах хүч  
ихтэйг хэлж буй хэрэг.

Аварга тосон рашааны урд талд "Өгөдэйг хаанд  
өргөмжилсөн газар" хэмээх тэмдгийг босгожээ.

Бидний амтархан уудаг Кукогоос илүүтэй хамар  
сэнгэнүүлсэн рашаан газрын гүнээс оргилон гарах нь эх нутаг  
минь юутай баян юутай өгөөмөр гэдгийг бахдуулан авай.Энэ  
дагшин умдаа нь эмчилгээний төгс чанартай бөгөөд ходоод  
гэдсэнд нэн сайн болохыг бичиж тавьсан танилцуулгаас нь  
уншиж мэдлээ.

Маргааш нь өглөө эртлэн хөдөлж Хэрлэн голыг гатлан Богд  
хаан уулын зүүн хойд талын өндөрлөгт орших Хүрэл тогоотын  
одон орон судлах станцад ирэв.

Эндхийн ажиллагааг МАХН-ын Төв Хорооны дарга агсан  
Д.Төмөр-Очирын гэргий одон оронч Нинжбадгар гуай биечлэн  
танилцуулсан нь ховор олдох завшаан байлаа.

Чингис хааны нэрэмжит Их засаг их сургуулийн жуулчдын  
баазад хүрэлцэн очиж аяллын ивээн тэтгэгч доктор профессор  
Н.Ням-Осортой уулзан сэтгэлийн үгээ ярилцан аян замын  
нариантай түүхээ инээлдэн хөөрөлдсөнөөр бидний энэ удаагийн  
аялал өндөрлөж Дархан нутгийнхаа зүг аяны жолоо заллаа.

Чингис хаан "...Та нар хөвгүүд дүү нар ноёдууд бидний  
араас үе залгах аль ч үеийн хэн боловч Монгол улсынхаа аугаа

---

*Д.Наянтай, Г.Батжаргал*

их төр ёсыг цаг үргэлж нүднийхээ ир мэт хайрлан дээдэлж  
түүнийг амь биеэрээ халхлан хамгаалж явбал зохино. Хэрвээ  
аль нэг өдөр алдаж осолдох аваас тэр цагт та нар Чингис хааныг  
хаанаас ч эрээд олохгүй шүү! гэж үеийн үедээ хойчлуулан захиж  
Монгол улсын тулгар их төрийг мөнхөд бат хүчирхэг байлгахын  
төлөө санаа зовнин энэхүү алдарт гэрээслэлээ хэлжээ/8-ын  
30-р тал/.

Элэвч элэгдэвч омгоо бүү март  
Их ч бага ч түүхээ бүү март хэмээн  
Өвөг дээдэс минь сануулна  
Өрлөг түүх минь өгүүлнэ.  
Энэ аяллын эрхэм олзын нэгтгэл билээ. Эмхлэн найруулах  
номын учир ийн бөлгөө.

*/Бэсүд овгийн Чимэдцэрэнгийн Оюунцэцэг/*

### Дурсамж

Би оны 6-р сард болсон эх үрсийн баяраар 2002 оны "Манлай" ээж өргөмжлөл хүртэж улмаар их эзэ.ч Чингис хааны их хатан Бөртэ хатны хөшөөний суурь тавихад оролцох авто аялалаар Хэнтий, Дорнод аймгаар явж эх орныхоо түүхэн газруудаар явсандаа туйлын баяртай байна. Алс баруун нутагт төрж өссөн миний бие зүүн аймгийн нутагт байдаг эзэн Чингисийн түүх, төрж өссөн газар, монголын түүхэнд холбогдох олон арван газар усны нэр, намтрыг нүдээрээ үзэж, нутгийн ахмадуудын домог яриаг сонсож эх орноо танин мэдэж өөрийн эрхгүй бахархах сэтгэл төрж билээ.

Бидний аялалын маршрут нь Дархан-Уул аймгаас эхлэж Их Засаг их сургуулиар дайрч Хэрлэн гол, Хэнтий аймаг түүний сумууд, Дорнод аймаг байгалийн сайхан цогцолсон Хөдөө арал, Аварга тосон гэж олон түмэнд алдаршсан рашаан нуур, Хүрэл тогоот зэрэг байлаа. Бид очсон газар бүхэндээ түүхэн газруудыг судлан мэдэж авах, зураг болгон буулгах, хойч үедээ таниулахад бэлдэж тэмдэглэл хөтлөж явцгаасан юм. Энэ нутагт үе үеийнхний булш, хөшөө дурсгал олноор үлдэж, төрөлх нутагтаа амьдарч байсан буйр, бууц нь хойч үеийнхэндээ дурсагдан хоцорсон байна. Энэ нутгийн уул ус нь түүх домог өгүүлнэ гэж хэлж болно.

Бидний аялагчид эзэн Чингисийн төрсөн нутгаар аялаж явахдаа зөвхөн түүх дурсгалын газруудыг үзээд зогсохгүй тэр нутгийн ард түмний зан заншил, уламжлал, хөдөлмөрч сайхан чанаруудыг биширч явлаа. Буриад зон бол маш ажилсаг амьдрах ухаан нь хөгжсөн, зан сайтай хүнийг зочлох хүндлэх талаар овог дээдсийн уламжлалаа үлдээж хоцорсон ард түмэн юм байна. Хөдөөгийн малчид нь дүнзэн байшинд амьдарч цөцгийн тосоо өөрсдөө бэлтгэж хүнсэндээ хэрэглэх нь ерийн хэрэглээ болсон нь бахархуштай байв. Бидний Монголчууд хорвоогийн түмэн газарт хөл тавьж, мэлмий нээн, хөх тэнгэрийн дор тэргүүн өргөн явахдаа яаж амьдарч, бүтээн тэмцэж хөлөө олж явах учиртайг энэ цаг үедээ өвлүүлэн үлдээж өгсөн их түүх

*Д.Наянтай. Г.Батжаррал*

маань бидэнд их учир утгыг нээн байгааг би хувьдаа ухааран хүндэтгэж, түүх домгоо бишрэн дээдлэх ухаарлыг хойч үедээ үлдээх таниулахад хичээх болно.

Би ахмад хүний хувьд хойч үе 21-р зууны залуучуудад эхлээд эх орныхоо түүх, дурсгалын газруудтай танилцаад дараа нь гадаад оронтой танилцах нь зүйтэй юм байна. Гадаадын орноос илүү манай нутагт үзэх, судлах зүйл их байдаг юм байна. шүү гэж хэлэхийг хүсье. Зуны сайхан дэлгэр цагт байгууллага гэр бүл, найз нөхөд ханьсан нийлж сайхан аялал зохион байгуулах боломж манай аймгийн хувьд бүрэн байгаа юм байна.

Бидний аялагчид 11 хүний бүрэлдэхүүнтэй явж өмнөө тавьсан зорилтоо бүрэн биелүүлж, хөшөөний суурийг Дорнод аймгийн төвд тавьж их хатны хөшөөг босгоход эмэгтэй хүн бүр 100 төгрөгийн хандив өргөх уриалга гарган хэрэгжүүлэх эхлэл тавилаа. Эх орныхоо түүх дурсгалын өлгий нутгаар аялаж, танин мэдэх мэдлэгээ дэслүүлэх боломж олгосон аймгийн Эмэгтэйчүүдийн Холбоо, ахмадын холбоонд баярласан талархсанаа энэ дашрамд илэрхийлж дурсамжаа жаргаая.

*Дурсамжаа бичсэн аялалын бүрэлдэхүүний нэг  
магистр Дэлэгийн Тогтуур.  
2002он.*

Бөртэ хатны уугуул  
нутагаар \_\_\_\_\_

2001 ОНД /ЧИНГИС ХААНЫ ТӨРСӨН НУТГААР/  
НОМОНД ОРСОН АЯЛЛЫН ЗАМ


Газрын нэр км

1.	Дархан-Улаанбаатар	230
2.	Улаанбаатар-Бага-Нуур	140
3.	Бага-Нуур-Цэнхэрмандал	55
4.	Цэнхэрмандал-Өмнөдэлгэр	100
5.	Өмнөдэлгэр-Ихсийн газар/-Биндэр	140
6.	Биндэр-Дадал-/Гурван нуур /	200
7.	Дадал-Норовлин	60
8.	Норовлин-Хурх	130
Э.Хурх -	Өмнөдэлгэр	117
Ю.Өмнөдэлгэр-	Жаргалтхаан	55
11.	Жаргалтхаан-Дэлгэрхаан	45
12.	Дэлгэрхаан-Бага-Нуурын уурхай	140
13.	Багануур -Улаанбаатар хот	140
14.	Улаанбаатар-Дархан	230

**Бүгд** 1920

Явж болох зам

1.	Норовлин-Батноров	97
2.	Батноров-Өндөрхаан	105
3.	Өндөрхаан-Дэлгэрхаан	122



Бөртэ хатны уугуул  
нутгаар \_\_\_\_\_

2002 ОНД “БӨРТЭ ХАТНЫ УУГУУЛ НУТГААР”  
НОМОНД ОРСОН АЯЛАЛЫН ЗАМ

Газрын нэр км

1. Дархан-Улаанбаатар	230
2. Улаанбаатар-Налайх	40
3. Налайх-Эрдэнэ сум	36
4. Эрдэнэ сумаас Баяндэлгэр сум	30
5. Баяндэлгэр сумаас-Бага нуурын уурхай	30
6. Бага нуур-Хэрлэнгийн гүүр	10
7. Хэрлэнгийн гүүр / Цэнхэр мандал	55
8. Цэнхэр мандал - Өмнөдэлгэр	110
9. Өмнөдэлгэр - Биндэр сум	110
10. Биндэр сум - Дадал сум	100
11. Дадал сум - Норовлин сум	55
12. Норовлин сум - Цагаан овоо	120
13. Цагаан овоо - Чойбалсан хот	110
14. Чойбалсан /- Баян овоо сум	185
15. Баян овоо- Идэрмэг сум	70
16. Идэрмэг - Өндөрхаан хот	51
17. Өндөрхаан -Мөрөн сум	22
18. Мөрөн - Дэлгэрхаан сум	100
/Чингисийн онгон цогцолбор/	
19. Дэлгэрхаан -Хэрлэнгийн гүүр	100
20. Хэрлэн-Улаанбаатар	150
21. Улаанбаатар-Дархан	230
<b>Бүгд</b>	<b>2000</b>





**“Чингис хааны төрсон нутгаар” 2001 он,  
“Бөртэ хатны уугуул нутгаар” 2006 он  
номыг зохиогч:**



**(Зүүн гараас)  
Сайн эрс овгийн Дашдоржийн Наянтай  
Шарайд овгийн Гүрийн Батжаргал нар  
Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын Хөдөө аралд  
байгуулсан Чингис хааны онгоны их өргөөнд  
2002 он**